

Баянхонгор аймгийн Аудитын газар

АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БАГ-2017/43/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: Bayankhongor.gazar.gov.mn

Тэргүүлэх аудитор: Ё. Сугаррагчаа

Утас: 93128844 Цахим хаяг: sugar_bhr1989@yahoo.com

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

Аудитор: Б.Должмаа

Утас: 88119345 Цахим хаяг: b_doma2021@yahoo.com

1 CONTENTS

2 Аудитын гэрчилгээ.....	2
3 Аудитын тайлан.....	4
3.1 Оршил.....	4
3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
3.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
3.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
3.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
3.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
3.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
3.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
3.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал.....	8
3.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
3.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
3.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
3.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
3.12 Шилэн дансны мэдээлэл.....	10
3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
3.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
4 Менежментийн захидал	12
4.1 ЗАРДАЛ	13
4.2. ОРЛОГО.....	14
5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
5.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
5.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
5.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
5.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн ТАЙЛАН	20
5.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5.6 Төлбөрийн акт.....	22-23



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2017. 02. 02 № 2/05

танай _____-ны № _____ т

Г

Г

Аудитын гэрчилгээ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккурэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Баянхонгор аймгийн Аудитын газраас аudit хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аudit хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аudit хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс анgid эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон

тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувалсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ё.СУГАРРАГЧАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аудитын тайланг Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Дард овогтой Алтангэрэлд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дунд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлгээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.01-нээсс 2017.02.02-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.02-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр

төлөвлөн, Баянхонгор аймгийн Аудитын газрын аудитор Батаа овогтой Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.23 -нд төрийн аудитын байгууллагад 2016.11.30-ны өдрийн 193-р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар “Иргэд газар, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн болон газрын кадастрын талаарх төрөөс үзүүлэх үйлчилгээг ил тод, шудрага, хөнгөн шуурхай үзүүлж, тэдний эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.” эрхэм зорилгын дор Газар зохион байгуулалт, геодизи зураг зүйн газрын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Барилгын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн ““Санхүүгийн тооцоолох компаний Acolous-4 санхүүгийн программ” програм хангамж ашиглажээ.

2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуульяа.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглувансан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 29 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бурийг дахин нарийвчлан үнэлэхэд 9 асуудал эрсдэл өндөр, 1 асуудал эрсдэл дунд, 7 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 48 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 9 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь -тай холбоотой юм.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 362,2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь буюу 7,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурийг нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулдаггүй орлого нэмэгдэж тооцогдох тул ач холбогдол багатай, нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул үр дүнгийн тайлангийн зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 8 чиглэлээр 29 эрсдэлтэй асуудалд 29 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 44 хувь буюу 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(мянган төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	3	509.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	203.6	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	4	713.5	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгооор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежментийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

2.9.1.1 2016 оны 02 дугаар сард ажилтан Б.Наранхатанд ээлжийн амралтын олговрыг буруу тооцоолсноос 203678 төгрөгийг илүү олгожээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалт гэсэн заалтыг зөрчсөн

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Байхгүй.

**2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй
асуудал
Байхгүй.**

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БЮОУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

2.11 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 235364400, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	290364400	275971176.18	-4.9%	-1.43
1.1	Урсгал зардал	290364400	275971176.18	-4.9%	-1.43
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

3

Төсөвт зардлын гүйцэтгэл 97,1 хувь байгаа нь 1 ажилтан тэтгэвэрт гарсан, 1 ажилтан жирэмсний амралт авснаас цалингийн зардал, цахилгааны гэмтэл гарсаны улмаас 2-р давхарын заал ашиглаагүйгээс цахилгааны зардал хэмнэгдсэн. Халаалтын зардлыг 8 сараар тооцож төлөвлөж, гүйцэтгэлээр 7 сараар тооцоо хийснээс тус зардал 1857,5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 86,4 хувь байгаа нь Үндсэн үйл ажиллагааны орлогоор 55,0 сая

төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 47,5 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөө 7,5 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар 6701,5 мянган төгрөг төвлөрснийг урстгал зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 2016 оны 11-р сард Нийцлийн аудитаар хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2016.05.04-ны өдрийн 183 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

ДД	Өмнөх аудитаар илэрсэн зөрчил	Өгөгдсөн зөвлөмж	Хэрэгжилт	Биелэлт
1	Орлого	3	1. Өөрийн орлогыг зөв төлөвлөж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах 2. Орлогыг төрөл тус бүрээр ангилж бүртгэх 3. Сангийн сайдын 2008 оны 09 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачилсан заавар”-ын дагуу тайланг үнэн зөв гаргах	100%
2	Зардал	4	1. Үндсэн хөрөнгийн элэгдлийг санхүүгийн программд зөв бодуулах. 2. Санхүүгийн программд орлого, зарлагын гүйлгээг огноогоор зөв бүртгэх 3. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай оны эцэст гэрээг дүгнэж байх 4. Томилолтын зардлыг анхан шатны баримтыг үндэслэн олгох	100%
3	Авлага, еглөг	1	1. Томилолтын урьдчилгаа олгох үед авлагаар бүртгэж, НББ-ын стандартыг мөрдөх	100%
4	Үндсэн хөрөнгө,	3	1. Нярвын гаргасан тайланг шалгаж хүлээн авч, нягталж, санхүүгийн тайланг бэлтгэх	100%

бараа материал		2. Хөрөнгийн дахин үнэлгээ дансны 777610,42 төгрөгийн зөрүүг эргэн нягталж, өмнөх онуудаас хөөн шалгаж зөв болгох 3. Ашиглагдахгүй принтерийн хоруудыг ГХГЗ3Г-т хүсэлт тавьж ашиглагдах принтерийн хороор солиулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх	
Дүн	11		100%

2.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайландаа аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлгагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, няглан бодох бүртгэл, тайллагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын няглан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланда тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилтийн талаарх хариуг 2017 оны 04 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланда шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 ЗАРДАЛ

Илрүүлэлт:

1. Тайлант оны цалингийн зардал, НДШ-ийн зардлыг хооронд нь зөрүүлж бичилт хийснээс цалингийн зардал 81,7 мянган төгрөгөөр илүү, НДШ-ийн зардал мөн дүнгээр дутуу илэрхийлэгдсэн байна.

2. Томилолтын хуудас дээр томилолтоор ажиллах хоног, он, сар, өдрийг дутуу бөглөдөг, томилолт сунгасан тэмдэглэлийг хийдэггүй байна.

3. Томилолтын урьдчилгааг олгоходоо авлагаар бүртгэлгүй, томилолтын зардалд бичжээ.

4. 2016 оны 11 дүгээр сард ажилтанд ногдуулсан 20%-ийн сахилгын шийтгэлийг бодохдоо үндсэн цалинг хасалгүй, цалингийн суутгалаар 256,2 мянган төгрөгийг хасч тооцсон байна.

Зөвлөмж

- Анхан шатны баримтанд үндэслэн нягтлан бodoх бүртгэлийн бичилтийг зөв бичих
- Томилолтын хуудасыг бүрэн бөглөх, түүнд тавих хяналтыг сайжруулах
- Ажиллагсдад олгосон томилолтын урьдчилгааг шууд зардалд бүртгэлгүй, авлагаар бүртгэх
- Сахилгын шийтгэл ногдуулахдаа үндсэн цалинг бууруулж, холбогдох НББ-ийн бичилтийг үнэн зөв бичих

Хариуцах ажилтан

Байгууллагын дарга Д.Алтангэрэл
Нягтлан бодогч С.Гэрэлмаа

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

1. Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулах /Т, И, Х, Ү /
2. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх / Ү /
3. Зардлыг санхүүгийн тайландаа бүрэн тусгаагүй байх / И, Э /
4. Баримтын бүрдүүлэлгүй орлого, зарлага хүлээн зөвшөөрсөн байх /Ү/

3.2 ОРЛОГО

Илрүүлэлт:

1. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 55,0 сая төгрөгийн орлого оруулахаас гүйцэтгэлээр 47,5 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөө 7,5 сая төгрөгөөр тасарчээ.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан хуваарийг 20,2 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Зөвлөмж

- Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнах

Төсвийн захирагчийн хариу

Хариуцах ажилтан

Байгууллагын дарга Д.Алтангэрэл
Нягтлан бодогч С.Гэрэлмаа

Эрсдэл

1. Орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн байх
2. Орлого санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байх
3. Орлогыг буруу ангилан бүртгэсэн байх,
4. Хүү торгууль, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байх
5. Орлогын гүйцэтгэлийг буруу тооцоолсон байх

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,075,642.40	18,247,820.85
35	БАРАА МАТЕРИАЛ	24,075,642.40	18,247,820.85
35300	Бэлэн бүтээгдэхүүн	55,346.00	55,346.00
354	Хангамжийн материал	24,020,296.40	18,192,474.85
35410	Бичиг хэргийн материал	5,946,134.24	2,039,740.00
35420	Аж ахуйн материал	1,209,100.00	1,438,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,083,200.00	2,760,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,781,862.16	11,954,234.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	289,309,749.90	283,286,204.98
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	289,309,749.90	283,286,204.98
392	Биет хөрөнгө	288,887,083.23	282,312,205.05
39201	Барилга, байгууламж	155,468,454.00	158,348,454.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,381,677.57	-25,015,735.17
39203	Авто тээврийн хэрэгсэл	102,491,750.00	102,491,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,934,405.86	-64,683,030.86
39205	Машин, тоног төхөөрөмж	194,566,162.03	246,442,542.03
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,828,059.66	-143,099,554.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,763,198.37	26,763,198.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,258,338.08	-18,935,418.60
393	Биет бус хөрөнгө	422,666.67	973,999.93
39301	Програм хангамж	2,405,000.00	3,285,000.00
39302	Хасагдуулга	-1,982,333.33	-2,311,000.07
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	313,385,392.30	301,534,025.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	40,650.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,650.00	00.00
413	Өглөг	40,650.00	00.00
4136	Бусад өглөг	40,650.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	40,650.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	313,344,742.30	301,534,025.83
51	Засгийн газрын хувь оролцоо	313,344,742.30	301,534,025.83
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	306,277,027.70	306,277,027.70
51101	Өмч: -Төрийн өмч	306,277,027.70	306,277,027.70
512	Хуримтлагдсан үр дүн	4,301,709.60	-7,509,006.87
51210	Өмнөх үеийн үр дүн	4,301,709.60	4,301,709.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,810,716.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,766,005.00	2,766,005.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	313,385,392.30	301,534,025.83

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,906,870.40	350,432,022.75
11	ТАТВАРЫН ОРЛОГО	18,397,999.00	00.00
110	Орлогын албан татвар	18,397,999.00	00.00
1100	Хувь хүний орлогын албан татвар Төлбөрт таавар, бооцоот тоглоом эд мөнгөний	18,397,999.00	00.00
110007	хонжворт сугалааны орлого	3,919,839.00	00.00
110008	Шууд бус орлого	14,478,160.00	00.00
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,919,839.00	00.00
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,919,839.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,758,659.30	100,978,660.00
120	Нийтлэг татварын бус орлого	83,758,659.30	100,978,660.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	83,758,659.30	100,978,660.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,898,301.40	47,522,280.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,860,357.90	53,456,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,842,472.10	14,088,962.75
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,907,740.00	235,364,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах	7,842,472.10	6,701,560.00
131103	ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны	7,842,472.10	00.00
131105	хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,701,560.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	3,297,802.75
133003	Хөрөнгийн	00.00	3,297,802.75
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	00.00	4,089,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	4,089,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	352,344,563.30	362,242,739.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,787,795.30	283,505,255.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭНИЙ ЗАРДАЛ	301,787,795.30	283,505,255.40
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	147,838,984.50	132,199,056.00
210101	Цалин Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	147,838,984.50	132,199,056.00
2102	шимтгэл	16,316,911.00	14,741,730.18
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	16,316,911.00	14,741,730.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,845,920.00	15,889,799.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,590,258.00	1,277,576.00
210302	Түлш, халаалтын зардал	14,747,948.00	13,072,543.00
210303	Цэвэр, бохир үсны зардал	1,507,714.00	1,539,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,749,469.60	20,204,352.70
210401	Бичиг хэргийн материал	3,979,628.60	6,722,204.24
210402	Тээвэр, шатахууны зардал	2,580,170.00	2,826,900.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,104,771.00	1,251,315.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	84,900.00	9,403,933.46
2105	Нормативт зардал	327,555.00	344,050.00

**Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	327,555.00	344,050.00
2106	Эд хогшил, ургал засварын зардал	1,444,700.00	1,464,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,200,000.00	00.00
210604	Ургал засвар	244,700.00	1,464,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,073,900.00	1,562,700.00
210702	Дотоод томилолтын зардал	2,073,900.00	1,562,700.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	14,531,620.00	5,077,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	00.00	4,487,500.00
210801	Үйлчилгээний төлбөр хураамж	00.00	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	53,460.00	271,600.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	00.00	218,150.00
210805	Тээврийн хэрэсглийн оношилгоо	14,478,160.00	00.00
	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	93,658,735.20	92,022,017.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,057,358.00	30,362,092.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,601,377.20	61,659,924.92
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хороодол	45,371,899.00	00.00
212	TATAAC	45,371,899.00	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	45,371,899.00	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	45,371,899.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,184,869.00	78,737,483.82
2132	Бусад ургал шилжүүлэг	5,184,869.00	24,299,700.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,919,839.00	4,089,600.00
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,810,100.00
213207		1,265,030.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	00.00	6,915,503.82
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,915,503.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	47,522,280.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	00.00	47,522,280.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-12,437,692.90	-11,810,716.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-12,437,692.90	-11,810,716.47
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН			
I	ДҮН (I)	312,204,040.40	293,677,840.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,919,839.00	00.00
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	3,919,839.00	00.00
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,919,839.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,376,461.40	47,522,280.00
120	Нийтлэг татварын бус орлого	78,376,461.40	47,522,280.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	78,376,461.40	47,522,280.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		
1200041	санхүүжих	63,898,301.40	47,522,280.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос		
1200042	санхүүжих	14,478,160.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,907,740.00	246,155,560.00
	Тусгай зориулалтын шилжүүлгээс		
131007	санхүүжих	229,907,740.00	235,364,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	6,701,560.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл		
	ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт		
131105	орлого	00.00	6,701,560.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс		
1340	санхүүжих	00.00	4,089,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	4,089,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	305,291,874.40	293,677,840.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	305,291,874.40	293,677,840.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,135,106.40	214,940,356.18
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	147,879,634.50	132,321,436.18
210101	Үндсэн цалин	125,266,082.50	114,060,658.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,835,652.00	3,438,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,777,900.00	14,822,078.00
	Ажил олгоочоос нийгтийн даатгалд төлөх		
2102	шимтгэл	9,405,145.00	14,660,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	3,918,052.00	9,345,572.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	739,398.00	691,596.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,435,600.00	1,356,300.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	354,500.00	353,177.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,957,595.00	2,913,355.00
	Байр ашиглалтай холбоотой тогтмол		
2103	зардал	17,845,920.00	15,889,799.00
210301	Гэрэл цахилгааны зардал	1,590,258.00	1,277,576.00
210302	Түлш, халаалтын зардал	14,747,948.00	13,072,543.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,507,714.00	1,539,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,586,221.00	6,891,525.00

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210401	Бичиг хэрэг	662,500.00	1,031,010.00
210402	Тээвэр, шатахуун	3,442,000.00	2,851,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,721.00	1,251,315.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,840,000.00	1,758,200.00
2105	Нормативт зардал	301,000.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	301,000.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	380,000.00	2,089,000.00
210604	Урсгал засвар	380,000.00	2,089,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,224,000.00	1,562,700.00
210701	Дотоод албан томилолт	2,224,000.00	1,562,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,016,802.40	7,291,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,337,130.00	6,701,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	53,460.00	271,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	218,150.00
210807	Газрын төлбөр	14,478,160.00	00.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	16,148,052.40	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,496,383.50	33,834,586.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,496,383.50	33,834,586.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,156,768.00	78,737,483.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,871,899.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,440,570.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	41,431,329.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,284,869.00	24,299,700.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	3,919,839.00	4,089,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	18,810,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,365,030.00	1,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,915,503.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,915,503.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	47,522,280.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	47,522,280.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,912,166.00	00.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,912,166.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл Дахин илэрхийлсэн	306,277,027.70	2,766,005.00	4,301,709.60	313,344,742.30
D03	үлдэгдэл	306,277,027.70	2,766,005.00	4,301,709.60	313,344,742.30
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	00.00	00.00	11,810,716.47	-11,810,716.47
D09	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	306,277,027.70	2,766,005.00	-7,509,006.87	301,534,025.83

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилаал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	290,364,400.00	275,971,176.18
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	290,364,400.00	275,971,176.18
210	Бараа, үйлчилгээний зардал	215,154,300.00	208,238,796.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,712,100.00	132,321,436.18
210101	Үндсэн цалин	115,347,000.00	114,060,658.18
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	3,465,000.00	3,438,700.00
210105	Гэрээт ажлын хөлс Ажил олгогчоос нийгмийн даатгалд	16,900,100.00	14,822,078.00
2102	төлөх шимтгэл	14,928,200.00	14,660,000.00
210201	Тэтгэврийн даатгал	9,499,847.00	9,345,572.00
210202	Тэтгэмжийн даатгал	678,691.50	691,596.00
210203	ҮОМШӨ ний даатгал	1,357,121.00	1,356,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	678,298.50	353,177.00
210205	Эрүүл мэндийн даатгал Байр ашиглалттай холбоотой тогтмол	2,714,242.00	2,913,355.00
2103	зардал	18,803,300.00	15,889,799.00
210301	Гэрэл цахилгаан	2,363,300.00	1,277,576.00
210302	Түлш, халаалт	14,940,000.00	13,072,543.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,539,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,201,600.00	6,891,525.00
210401	Бичиг хэрэг	1,105,000.00	1,031,010.00
210402	Тээвэр (шатахуун)	2,975,000.00	2,851,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд	1,557,600.00	1,251,315.00
210406	зүйлс	1,564,000.00	1,758,200.00
2105	Нормативт зардал	400,000.00	400,000.00

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2016 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210503	Нормын хувцас зөвлөн эдлэл	400,000.00	400,000.00
2106	Эд хогшил худалдан авах	2,089,000.00	2,089,000.00
210604	Урсгал засвар	2,089,000.00	2,089,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,593,700.00	1,562,700.00
210702	Дотоод албан томилолт Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	1,593,700.00	1,562,700.00
2108	үйлчилгээний төлбөр Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	590,500.00	589,750.00
210801	үйлчилгээний төлбөр, хураамж Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	55,000,000.00	47,522,280.00
210802	зардал	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	271,600.00	271,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	218,900.00	218,150.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	33,835,900.00	33,834,586.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,835,900.00	33,834,586.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн	20,210,100.00	20,210,100.00
213207	мөнгөн тэтгэмж	18,810,100.00	18,810,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,400,000.00	1,400,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ Тусгай зориулалтын шилжүүлгээс	290,364,400.00	275,971,176.18
131007	санхүүжих ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ	235,364,400.00	228,448,896.18
120004	АЖИЛЛАГААНАС Үндсан үйл ажиллагааны орлогоос	55,000,000.00	47,522,280.00
1200041	санхүүжих	55,000,000.00	47,522,280.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00

Хянах, зөвшөөрсөн:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Сугаррагчай* Ё. СУГАРРАГЧАА
Огноо: 2017/02/02



Хянасан:

МЕНЕЖЕР *Д. Цэцэгмаа* Д. ЦЭЦЭГМАА
Огноо: 2017/02/02

Боловсруулсан:

АУДИТОР *Б. Должмаа* Б. ДОЛЖМАА
Огноо: 2017/02/02